

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/07/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 70432545

цахим хаяг: erdenetsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Албан шаардлага	
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЦЭНГЭЛ ТАНАА

2022.02.24 № 2/106
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

021020739

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төгрөгөөр

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	632,313,161	625,300,199
34	УРЬДЧИЛГАА	55,000,000	7,200,000
34600	Урьдчилж гарсан зардал	55,000,000	7,200,000
35	БАРАА МАТЕРИАЛ	577,313,161	618,100,199
351	Түүхий эд материал	229,421,015	217,309,267
35130	Эм боох материал	229,421,015	217,309,267
354	Хангамжийн материал	347,892,146	400,790,932
35410	Бичиг хэргийн материал	3,493,860	4,328,350
35420	Аж ахуйн материал	18,858,058	18,825,458
35430	Сэлбэг хэрэгсэл	426,800	741,800
35440	Түлш, шатах тослох материал	150,730	-
35470	Бусад хангамжийн материал	324,962,698	376,895,324
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	823,420,114	765,738,520
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	823,420,114	765,738,520
392	Биет хөрөнгө	789,335,114	732,623,520
39201	Барилга, байгууламж, орон сууц	316,131,152	316,131,152
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,374,572)	(17,219,157)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	838,664,000	888,614,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	(681,257,366)	(727,188,107)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	386,364,381	398,214,381
39206	Хуримтлагдсан элэгдэл	(304,848,669)	(335,396,203)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,792,388	44,792,388
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,462,410)	(20,231,525)
39214	Бусад үндсэн хөрөнгө	284,908,990	284,908,990
39215	Хуримтлагдсан элэгдэл	(67,582,780)	(100,002,398)
393	Биет бус хөрөнгө	34,085,000	33,115,000
39301	Програм хангамж	4,140,000	4,140,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,255,000)	(2,225,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	31,200,000	31,200,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,455,733,275	1,391,038,719
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,766,350	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,766,350	-
413	Өглөг	1,766,350	-

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,766,350	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,453,966,925	1,391,038,719
51	Засгийн газрын хувь оролцоо	1,453,966,925	1,391,038,719
512	Хуримтлагдсан үр дүн	1,317,583,114	1,254,654,908
51210	Өмнөх үеийн үр дүн	967,949,915	1,317,583,114
51220	Тайлант үеийн үр дүн	349,633,199	(62,928,206)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	136,383,811	136,383,811
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,455,733,275	1,391,038,719

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,037,451,723	3,159,624,515
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	535,275,572	1,306,682,414
120	Нийтлэг татварын бус орлого	535,275,572	1,306,682,414
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	535,275,572	1,306,682,414
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,900	3,000,400
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	532,274,672	1,302,298,786
120009	Бусад орлого		1,383,228
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,176,151	1,852,942,101
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	848,103,200	945,825,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	848,103,200	945,825,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	654,072,951	907,116,901
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	382,321,900	548,279,526
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	209,417,600	274,724,510
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,333,451	84,112,865
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,683,561,580	3,222,552,721
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,683,561,580	3,222,552,721
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,630,836,622	3,137,667,848
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,126,000	569,680,889
210101	Үндсэн цалин	82,349,200	422,240,943
210102	Нэмэгдэл	27,576,800	129,929,809
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,200,000	17,510,136
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,342,500	78,210,283

210201	Тэтгэврийн даатгал	10,796,600	53,075,744
210202	Тэтгэмжийн даатгал	1,136,500	5,454,734
210203	ҮОМШӨ-ний даатгал	909,100	8,152,992
210204	Ажилгүйдлийн даатгал	227,300	988,713
210205	Эрүүл мэндийн даатгал	2,273,000	10,538,101
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,927,200	28,115,282
210301	Гэрэл, цахилгаан	9,532,200	4,081,404
210302	Түлш, халаалт	21,307,300	22,224,950
210303	Цэвэр, бохир ус	2,087,700	1,808,928
2104	Хангамж, бараа материалын зардал	48,799,280	62,321,678
210401	Бичиг хэрэг	10,533,350	6,670,760
210402	Тээвэр, шатахуун	26,321,000	49,591,250
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,154,160	4,476,078
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,790,770	1,583,590
2105	Нормативт зардал	313,327,611	330,826,221
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	313,293,711	330,826,221
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	326,000	1,350,000
210604	Урсгал засвар	25,000	1,350,000
2107	Томилолт, зочны зардал	-	8,581,900
210702	Дотоод албан томилолт	-	8,581,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	941,742,966	819,795,263
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	941,342,966	813,873,455
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,467,500
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	483,708
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	370,600
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000	3,600,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,245,066	1,238,786,333
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,293,928	1,119,304,739
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,951,138	119,481,594
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,724,958	84,884,872
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,859,870	2,667,450
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,782,800	2,667,450
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,865,088	82,217,422
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,865,088	82,217,422
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	353,890,143	(62,928,206)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	349,633,199	(62,928,206)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	136,383,811	967,949,915	1,104,333,726
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	136,383,811	967,949,915	1,104,333,726
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	-	349,633,199	349,633,199
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	136,383,811	1,317,583,114	1,453,966,925
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	136,383,811	1,317,583,114	1,453,966,925
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	136,383,811	1,317,583,114	1,453,966,925
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	136,383,811	1,317,583,114	1,453,966,925
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	-	(62,928,206)	(62,928,206)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	136,383,811	1,254,654,908	1,391,038,719

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,654,904,502	1,855,942,502
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,000,900	3,000,400
120	Нийтлэг татварын бус орлого	3,000,900	3,000,400
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,000,900	3,000,400
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,900	3,000,400
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,651,903,602	1,852,942,102
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	848,103,200	945,825,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	848,103,200	945,825,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	803,800,402	907,116,902
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	382,321,900	543,779,527
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	234,007,208	278,724,510

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	187,471,294	84,612,865
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,654,904,502	1,855,942,502
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,654,904,502	1,855,942,502
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,602,699,680	1,771,057,629
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	114,126,000	570,796,167
210101	Үндсэн цалин	82,349,200	420,816,221
210102	Нэмэгдэл	27,576,800	132,469,809
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,200,000	17,510,136
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,342,500	78,210,283
210201	Тэтгэврийн даатгал	10,796,600	53,075,744
210202	Тэтгэмжийн даатгал	1,136,500	5,454,734
210203	ҮОМШӨ-ний даатгал	909,100	8,152,992
210204	Ажилгүйдлийн даатгал	227,300	988,713
210205	Эрүүл мэндийн даатгал	2,273,000	10,538,101
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,302,200	28,115,282
210301	Гэрэл, цахилгаан	9,532,200	4,081,404
210302	Түлш, халаалт	21,682,300	22,224,950
210303	Цэвэр, бохир ус	2,087,700	1,808,928
2104	Хангамж, бараа материалын зардал	44,166,310	27,992,312
210401	Бичиг хэрэг	6,619,100	8,422,500
210402	Тээвэр, шатахуун	26,321,000	13,327,694
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,580,160	4,607,678
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,646,050	1,634,440
2105	Нормативт зардал	11,839,470	136,492,753
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,994,970	133,985,753
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,844,500	2,507,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,478,000	14,857,750
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,128,000	12,448,300
210604	Урсгал засвар	4,350,000	2,409,450
2107	Томиллолт, зочны зардал	-	8,581,900
210702	Дотоод албан томиллолт	-	8,581,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,375,445,200	905,857,883
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,375,045,200	892,736,075
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,467,500
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	483,708
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	370,600
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000	10,800,000

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	153,300
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	153,300
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,204,822	84,884,872
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,837,370	2,667,450
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,837,370	2,667,450
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,367,452	82,217,422
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,367,452	82,217,422
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	945,825,200	866,616,018
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,825,200	866,616,018
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	943,157,400	863,948,568
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	641,000,800	570,796,167
210101	Үндсэн цалин	459,361,600	420,816,221
210102	Нэмэгдэл	160,983,200	132,469,809
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,656,000	17,510,136
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,535,200	78,210,283
210201	Тэтгэврийн даатгал	60,895,000	53,075,744
210202	Тэтгэмжийн даатгал	6,410,100	5,454,734
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,128,000	8,152,992
210204	Ажилгүйдлийн даатгал	1,282,100	988,713
210205	Эрүүл мэндийн даатгал	12,820,000	10,538,101
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,542,800	28,115,282
210301	Гэрэл, цахилгаан	4,212,400	4,081,404
210302	Түлш, халаалт	22,521,000	22,224,950
210303	Цэвэр, бохир ус	1,809,400	1,808,928
2104	Хангамж, бараа материалын зардал	28,086,300	27,990,818
210401	Бичиг хэрэг	8,740,800	8,422,500
210402	Тээвэр, шатахуун	13,370,600	13,326,200
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,340,300	4,607,678
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,634,600	1,634,440
2105	Нормативт зардал	4,106,500	4,106,500

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,599,500	1,599,500
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,507,000	2,507,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,003,100	4,957,750
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,554,800	2,548,300
210604	Урсгал засвар	2,448,300	2,409,450
2107	Томилолт, зочны зардал	8,600,000	8,581,900
210702	Дотоод албан томилолт	8,600,000	8,581,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	141,129,400	141,036,568
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,991,900	127,914,760
210803	Даатгалын үйлчилгээ	1,467,500	1,467,500
210804	Тээврийн хэрэгслийн татвар	488,500	483,708
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	381,500	370,600
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000	10,800,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300	153,300
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,300	153,300
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,667,800	2,667,450
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,667,800	2,667,450
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,667,800	2,667,450
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	945,825,200	866,616,018
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	945,825,200	866,616,018
122005	Орон нутгийн төсвөөс	945,825,200	866,616,018
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	678,662,559	907,107,567
21	УРСГАЛ ЗАРДАЛ	678,662,559	907,107,567
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	678,662,559	907,107,567
2105	Нормативт зардал	-	132,386,252
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	132,386,252
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	678,662,559	774,721,315
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	678,662,559	774,721,315
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	774,721,315
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	774,721,315

II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
		678,662,559	907,107,567
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	678,662,559	907,107,567
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	382,321,900	543,771,686
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	234,007,208	278,724,510
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,333,451	84,611,371

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 02 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ний өдрийн 30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Мал эмнэлгийн газар нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах
- ✓ Мал, амьтны эрүүл мэнд, нийтийн эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавьж хэрэгжүүлэх
- ✓ Хуулийн хүрээнд батлагдсан журам, дүрэм заавар, стандарт норм, нормативыг мөрдүүлэх
- ✓ Малын эрүүл мэнд дэд хөтөлбөр, халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлын төлөвлөгөө, шимэгчлэх өвчнийг эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон бодлогын баримт бичгүүдийг батлуулж хэрэгжилтийг хангуулах
- ✓ Сумын мал эмнэлгийн тасаг, МЭҮН-үүдийг мэргэжил арга зүй удирдлагаар хангах
- ✓ Малын эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн сан байгуулах
- ✓ Хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МЭЕГ-аас 2021 онд байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1318.9 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 13.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9.2 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1245.4 сая төгрөгөөр буюу 60% хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өглөг, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд төрийн сангийн харилцах дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 618.1 сая төгрөг болж 40.8 сая төгрөгөөр өссөн нь бараа хангамжийн материал 40.8 сая төгрөгөөр шинэчилсэнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 277.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 1252.3 сая төгрөгөөр нийт 1529.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 1488.8 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Авлагын урьдчилж гарсан дансны үлдэгдэл оны эхэнд 55.0 сая төгрөг байснаас оны эцэст мэдээлэл холбооны сүлжээ холбох Дата ланд технологи ХХК-аас 7.2 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын авлагын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 823.4 сая төгрөг байсан бол оны эцэст 765.7 сая төгрөг болж 57.7 сая төгрөгөөр буурсан нь байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 823.4 сая төгрөг байсан бол оны эцэст 765.7 сая төгрөг болж 57.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 11.8 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2021 оны 02-р сарын 04-ны 36 тоот тогтоолоор үнэ төлбөргүй хүлээн авсан 49.9 сая төгрөгийн хөрөнгө орлого авч 119.5 сая төгрөгийн хөрөнгийн элэгдэл тооцож тайлант оны эцэст 765.7 сая төгрөгийн цэвэр хөрөнгийн үлэгдэлтэй байна

Тайлант оны эхэнд 1.7 сая төгрөгийн өр үүссэнийг тайланд оны хугацаанд бүрэн барагдуулж оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэлгүй бөгөөд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1254.6 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 945.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

МЭЕГ-аас тус байгууллагын төсвийг төсвөөс орлогыг 945.8 сая төгрөгөөр зардлыг 945.8 сая төгрөг батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 945.8 сая төгрөгийн төсөв баталснаас 945.8 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 945.8 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны орлогоос 3.0 сая төгрөг, нийт 948.8 сая төгрөгийн орлого олж 866.6 сая төгрөгийн зардал гарган 82.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 866.6 сая төгрөг буюу 85 хувь зарцуулсан нь үйл ажиллагааны орлогоос олсон 3.0 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, цалин, шимтгэлийн зардлаас 79.2 сая төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн МЭУСЗ-ын санхүүжилтээр 539.6 сая төгрөг, МЭЕГ-аас шүлхийн вакцинжуулалтын 252.5 сая төгрөг, Ногоон алт төслөөс 4.0 сая төгрөг, ОБГ-аас шүлхийн зардал 4.6 сая төгрөг, УМЭАЦТЛ-оос шинжилгээ тандалт судалгааны 22.2 сая төгрөг, малчдын тарилгын актаар 69.8 сая төгрөг, бусад орлогоос 14.4 сая төгрөг нийт 907.1 сая төгрөгийн санхүүжилт авч, зохих батлагдсан зардлын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсноор тус байгууллагад анхаарал татахуйц онцлог ажил гүйлгээ хийгдээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсноор санхүүгийн тайланд нөлөөлөхүйц ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 141 мэдээлэл хугацаандаа оруулсан 6 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн, 4 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 9.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 214.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 179.9 сая төгрөгийн 8 зөвлөмж өгөгдсөнөөс 9.9 сая төгрөгийн төлбөрийн акт бүрэн барагдуулж албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг МЭГ-ын даргын 2021 оны 09-р сарын 03-ны 207 тоот албан тоотоор ирүүлсэн байна. Хэрэгжилтийн хувь 90%-тай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулах, өмч хамгаалах комиссын дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй байгааг хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу цэгцлэх, хөрөнгө орлого аваагүй байгааг дараагийн санхүүгийн тайланд орлого авч тусгах, шатахуун зарцуулалтын дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 94.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.8 сая төгрөгийн төлбөрийн 1 акт, хөрөнгө цэгцлэхтэй холбоотой 1 албан шаардлага, 10.2 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч 80.4 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

1.1 Орлого, үр дүнтэй холбоотой

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Илрүүлэлт: Үр дүнд 4.1 сая төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлан 76.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, жинхэнэ зарлага 11.8 сая төгрөг зөрүүтэй тайлагнасан

Шийдвэрлэлт: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 80.4 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан алдааг 2022 оны „, дугаар сарын „,-ны „, тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.2 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын тарилгын акт малын тоо засвар ихтэй зарим тарилга тамга тэмдгээр баталгаажаагүй, хяналт бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналт сул 1.6 сая төгрөг,

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйд төлбөрийн акт тогтоох

1.3 МЭУСЗ-ын санхүүжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тарилгын актын хөлсийг мал эмнэлгийн үржлийн нэгжүүдэд илүү олгосон 2.2 сая төгрөг,

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлээгүйд төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1.5 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, өмч хамгаалах комиссын дотоод хяналт сул, бараа материалын дансанд үндсэн хөрөнгө болох хөрөнгүүд бүртгэлтэй, хөрөнгийн бүртгэлийг стандартын дагуу цэгцлээгүй, хөрөнгө орлого аваагүй

Шийдвэрлэлт: Хөрөнгө материалыг цэгцлэх талаар анхаарч хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага бичлээ

4.4 Зөвлөмж

1.7 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Онцгой байдлын газрын шүлхий өвчинтэй холбоотой гаргасан албан бичгээр шүлхийн шатахуун, хоолны зардлыг цалингийн зардлаас гаргаж зарцуулсан 7.5 сая төгрөг,

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,

1.8 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Агуулахад хадгалагдаж буй 2018 онд хугацаа дууссан вакцин, эм био бэлдмэл, оношлуур, урвалж, химийн бодисыг акталж устгаагүй

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллого хийж хөрөнгийн үр дүнг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

1.2 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тандалт, судалгаа, хяналт хийх шатахууны зардлын тооцоо бодоогүй, шатахуун олгож байгаа талоны тоо засвар ихтэй, хот дотор явж байгаа шатахууны зардал хэмнэгдээгүй, дотоод хяналт сул 545.9 мянган төгрөг,

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажаагүй гүйлгээ хийхгүй байх, шатахуун зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах

1.9 Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй олгосон хөрөнгө бүртгэж тайлагнаагүй 2.7 сая төгрөг,

Өгсөн зөвлөмж: Дараа оны санхүүгийн тайланд зохих хууль журмын дагуу хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, хөрөнгө орлого авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мал эмнэлгийн газар	7	94.4	1	80.4	1	3.8	1	0	4	10.2

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

